



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/53.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" 2009 оны 143 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 323 дугаар захирамжийн 4.12 дугаар заалтыг тус тус үндэслэн үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газраас үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар, ажилтан, албан хаагчдын мэргэжил, ур чадвар, харилцааны түвшинг үнэлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулах байнгын ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Статистик судалгаа хариуцсан мэргэжилтэн Үйлчилгээний байгууллагууд хариуцсан мэргэжилтэн Жуулчны мэдээллийн төвийн менежер
Нарийн бичгийн дарга:	Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

2. Гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжээс авах судалгааны маягтыг боловсруулан, судалгааг цаасаар болон цахимаар тогтмол авах, судалгааны үр дүнг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт газрын хуралд хагас, бүтэн жилээр танилцуулж байхыг Ажлын хэсэгт даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА